



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Монгол Үндэсний Ардчилсан нам (МҮАН)-ын  
шинэчилсэн дүрмийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Г.Банзрагч, Н.Батчимэг, Н.Батзориг, Ц.Оч, Э.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Монгол Үндэсний Ардчилсан намын (МҮАН)-ын шинэчилсэн дүрмийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Б.Батцэрэнгийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Үндэсний Ардчилсан нам (МҮАН)-ын дарга Б.Цогтгэрэлээс “Намын эрх барих дээд байгууллагыг 2025 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хуралдуулж, намын дүрэм, хөтөлбөрт өөрчлөлт оруулан баталж, дотоод зохион байгуулалтаа хууль, намын дүрэмд нийцүүлсэн шийдвэрүүд гаргалаа. Монгол Үндэсний Ардчилсан намын Их хурлаар намын дүрэм, хөтөлбөрийг хэлэлцэн батлахдаа тогтоол, албан бичигт дурдсан алдаа, зөрчилтэй заалтуудыг өөрчлөн хууль болон Шалгах хуудас 2-т заасан шалгуурт тус тус нийцүүлэн баталсан. Зохих журмын дагуу шийдвэрлэж өгнө үү” гэсэн агуулга бүхий өргөдлийг 100 хуудас баримт, 1 ширхэг флашны хамт 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн.

Бүртгэлийн албанаас Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 2.5-д зааснаар шалгах ажиллагааг явуулж, 72 хуудас баримт бичиг, тайлбар нэмэлтээр хүлээн авсан.

Монгол Үндэсний Ардчилсан нам (МҮАН)-ын шинэчилсэн дүрмийг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын дагуу шалгаж, нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Монгол Үндэсний Ардчилсан нам (МҮАН)-ын шинэчилсэн дүрмийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэлээ. Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17

дугаар зүйлийн (цаашид “Хуулийн” гэх) 17.2 дахь хэсэгт “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:” гээд 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж заасан. Монгол Үндэсний Ардчилсан нам (МҮАН)-ын Ээлжит бус VIII Их хурлаар намын шинэчилсэн дүрмийг баталсан үйл ажиллагаа нь хуулийн дээрх зохицуулалт болон Улсын дээд шүүхэд бүртгэлтэй тухайн намын дүрэмд нийцсэн байна.

*Нэг.Намын удирдах дээд байгууллага болох Их хурлыг зарлан хуралдуулсан үйл ажиллагааны талаар:*

Монгол Үндэсний Ардчилсан нам (МҮАН)-ын дүрэм (2011 он)-ийн 7.3.2-т “Намын төлөөллийн төв байгууллага нь дөчөөс доошгүй төлөөлөгчөөс бүрдсэн МҮАН-ын Бүгд хурал мөн”, 8.2-т “Ээлжит бус хурлыг Бүгд хурал зарлаж болно”, 8.4.5-д “Намын Удирдах зөвлөл санал болгосноор намын Бүгд хурлаас намын ээлжит бус Их хурлыг хуралдуулах шийдвэр гаргавал тус намын ээлжит бус Их хурал хуралдаж болно”, 8.5-д “Намын Их хурлын төлөөлөгчдийг бүгд хурлын гишүүд, шат шатны намын идэвхтэн гишүүд болон бусад гишүүдээс намын удирдах зөвлөл сонгоно”, 9.4-т “Намын Бүгд хурлын ээлжит бус хуралдааныг Удирдах зөвлөл санал болгосноор Намын дарга зарлан хуралдуулна” гэж тус тус заажээ.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтаас үзэхэд, Монгол Үндэсний Ардчилсан нам (МҮАН)-ын Удирдах зөвлөлийн санал болгосны дагуу намын даргын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 014 дүгээр тушаалаар намын Ээлжит бус Арван долдугаар Бүгд хурлыг 2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хуралдуулахаар шийдвэрлэсэн, улмаар Бүгд хурал нь гишүүдийн олонх буюу 31 гишүүний бүрэлдэхүүн (биечлэн-22, онлайн-9)-тэй хуралдаж, 05 дугаар шийдвэрээр намын Ээлжит бус VIII Их хурлыг 2025 оны 12 дугаар сарын 13-ны өдөр товлон зарлаж, тус Их хурлын төлөөлөгчдийг сонгож, нэрсийн жагсаалт гаргаж батлахыг намын Удирдах зөвлөлд даалгаж шийдвэрлэсэн байна.

Үүний дагуу Удирдах зөвлөлийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/29 дүгээр шийдвэрээр Ээлжит бус VIII Их хурлын төлөөлөгчдийн тоог 167 байхаар тогтоож, нэрсийн жагсаалтыг баталсан (Их хуралд намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, намын 7 дугаар Их хурлын төлөөлөгчөөр сонгогдож байсан гишүүдээс сонгох, Бүгд хурлын гишүүдийг оруулсан), улмаар хурлын зарыг намын фэйсбүүк хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, утсаар намын гишүүд, төлөөлөгчдөд хүргэсэн болох нь холбогдох баримтуудаар тогтоогдсон болно.

Монгол Үндэсний Ардчилсан нам (МҮАН)-ын 2025 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Ээлжит бус VIII Их хуралд 167 төлөөлөгч оролцохоос 131 (78.4 хувь) гишүүн биечлэн оролцсон, үүнээс 40 нь орон нутгийн төлөөлөл бөгөөд эдгээрийг намын гишүүн, төлөөлөгч мөн эсэхийг шалгахад зөрчилтэй зүйл тогтоогдсонгүй.

*Хоёр.Намын шинэчилсэн дүрмийг баталсан талаар:*

Хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, 17.2.1-д “намын дүрэм, ...батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж;

Монгол Үндэсний Ардчилсан нам (МҮАН)-ын дүрэм (2011 он)-ийн 7.3.1-д “МҮАН-ын удирдах дээд байгууллага нь тус бүр 10-аас доошгүй гишүүдээ төлөөлсөн 150-200 төлөөлөгчөөс бүрдсэн намын Их хурал мөн”, 8.3-т “Намын Их хурлын бүрэн эрхэд доорх асуудлууд хамаарна”, 8.3.1-д “Бүгд хурал, Хариуцлагын хорооны тайланг хэлэлцэж, Бүгд хурлын хуралдаануудаар баталсан дүрмийн өөрчлөлтүүдийг нөхөн ёсчилно”, 8.4.1-д “Намын Их хуралд сонгогдсон нийт төлөөлөгчдийн гуравны хоёроос илүү нь оролцож байгаа бол Их хурлыг хүчинтэйд тооцно”, 8.4.3-т “Намын Их хуралд хэлэлцэж буй асуудлыг хуралдаанд оролцож буй төлөөлөгчдийн олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана” гэж тус тус заасан.

Тухайн намын 2025 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Ээлжит бус VIII Их хуралд 131 төлөөлөгч оролцсоноос 129 буюу 98.5 хувийн саналаар 2023 онд батлагдсан Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн боловсруулсан намын шинэчилсэн дүрмийн төслийг дэмжиж, 2 төлөөлөгч буюу 1.5 хувь нь санал өгөхөөс түдгэлзжээ. Үүнээс үзэхэд, Ээлжит бус VIII Их хуралд оролцвол зохих 167 төлөөлөгчийн 2/3-оос илүү нь оролцож, хуралд оролцсон 131 төлөөлөгчийн олонхын саналаар намын дүрмийг шинэчлэн баталсан болох нь Ээлжит бус VIII Их хурлын болон Тооллогын комиссын хурлын тэмдэглэл, шийдвэрүүд, фото зураг, бусад баримтуудаар тогтоогдож байна.

Түүнчлэн, өмнөх Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 39 дүгээр тогтоол, Улсын дээд шүүхийн 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 03/3792 дугаартай албан бичгийн үндэслэлд дурдсан алдаа, зөрчлүүдийг бүрэн арилгажээ.

Монгол Үндэсний Ардчилсан нам (МҮАН)-ын шинэчилсэн дүрэм нь Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан байх тул бүртгэх хууль зүйн үндэслэлтэй гэж үзлээ.

Монгол Үндэсний Ардчилсан нам (МҮАН)-ын хөтөлбөр хуульд нийцсэн болохыг дурдав.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь заалтыг баримтлан Монгол Үндэсний Ардчилсан нам (МҮАН)-ын шинэчилсэн дүрмийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Б.БАТЦЭРЭН